



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариат сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/235-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 703333019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
----------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Албан шаардлага.....	17
4.2 Зөвлөмж.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
СХС	Сум хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НДС	Нийгмийн даатгалын сан



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ТАРИАТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.БУЯННЭМЭХ ТАНАА

2022.03.25 № 162
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын ТЕЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Тариат сумын ТЕЗ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	912,818.4	1,349,043.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	124,717.1	542,954.4
33	АВЛАГА	472,920.6	376,650.7
35	БАРАА МАТЕРИАЛ	315,180.8	429,438.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,238,308.2	8,794,743.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,238,308.2	8,794,743.0
39200	Биет хөрөнгө	6,051,778.6	8,570,105.6
39300	Биет бус хөрөнгө	186,529.7	224,637.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,151,126.7	10,143,786.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	285,054.7	17,058.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	285,054.7	17,058.1
41300	Өглөг	285,054.7	17,058.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,866,071.9	10,126,728.2
51	Засгийн газрын хувь оролцоо	6,866,071.9	10,126,728.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,341,144.9	2,610,040.4
51200	Хуримтлагдсан үр дүн	1,549,190.9	3,158,757.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,975,736.2	4,357,930.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,151,126.7	10,143,786.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,946,968.3	5,953,565.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	185,476.9	281,130.0
110	Орлогын албан татвар	99,334.8	89,650.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	99,334.8	89,650.7
113	Хөрөнгийн албан татвар	7,350.0	118,460.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	78,792.1	73,018.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	414,484.4	1,415,092.5
120	Нийтлэг татварын бус орлого	414,484.4	1,415,092.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,347,006.9	4,257,342.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,858,979.0	4,591,347.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,858,979.0	4,591,347.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,195,137.5	4,488,320.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,810,334.3	2,360,700.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	233,016.1	313,002.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	455,486.2	550,601.1
2104	Хангамж, бараа материалын зардал	109,397.9	124,434.3
2105	Нормативт зардал	83,814.3	548,861.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,323.6	15,481.9
2107	Томилолт, зочны зардал	4,449.6	3,395.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,102.1	58,288.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	427,213.4	513,555.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	663,841.5	103,027.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	87,989.2	1,362,217.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	140,198.4	82,938.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-52,209.2	1,279,279.3

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,917,439.1	6,917,439.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	886.7	886.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,918,325.9	6,918,325.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-44.7	-44.7
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	-52,209.2	-52,209.2
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,866,071.9	6,866,071.9
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,866,071.9	6,866,071.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,981,734.1	1,981,734.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,847,806.0	8,847,806.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-357.1	-357.1
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	1,279,279.3	1,279,279.3
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,126,728.2	10,126,728.2

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,660,805.5	4,650,142.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	185,476.9	281,130.0
110	Орлогын албан татвар	99,334.8	89,650.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	99,334.8	89,650.7
113	Хөрөнгийн албан татвар	7,350.0	118,460.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	78,792.1	73,018.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	25,068.8	22,150.7
1181	Газрын төлбөр	28,318.6	21,033.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	25,404.8	29,834.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	128,321.7	178,924.0
120	Нийтлэг татварын бус орлого	128,321.7	178,924.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,347,006.9	4,190,088.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,429,400.6	4,114,664.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,429,400.6	4,114,664.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,766,994.2	4,012,171.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,810,334.6	2,359,879.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	235,853.2	310,963.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385,288.0	807,263.7
2104	Хангамж, бараа материалын зардал	82,852.4	94,753.2

2105	Нормативт зардал	91,364.0	268,556.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,110.0	11,220.5
2107	Томилолт, зочны зардал	4,449.6	3,395.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,360.4	76,681.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,382.1	79,458.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	662,406.3	102,493.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	231,405.0	535,477.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	175,101.1	117,240.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	175,101.1	117,240.2
2200	Дотоод эх үүсвэрээр	175,101.1	117,240.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-175,101.1	-117,240.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-174,212.4	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	173,000.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,212.4	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-117,908.4	418,237.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	242,625.5	124,717.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	124,717.1	542,954.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,374,430.2	3,915,517.7	458,912.5	89.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,922,675.3	3,873,397.0	49,278.3	98.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,872,119.6	3,825,739.3	46,380.3	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,288,580.7	2,288,580.7	0.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	307,592.9	305,744.8	1,848.1	99.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	805,535.9	803,863.7	1,672.2	99.8
2104	Хангамж, бараа материалын зардал	118,834.0	106,648.1	12,185.9	89.7
2105	Нормативт зардал	188,729.6	159,110.2	29,619.4	84.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,953.5	27,953.5	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,919.6	3,369.6	550.0	86.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,524.1	45,019.4	504.7	98.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,449.3	85,449.2	0.1	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,555.7	47,657.7	2,898.0	94.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,555.7	47,657.7	2,898.0	94.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	295,465.7	42,120.7	253,345.0	14.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	156,289.2	-	156,289.2	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,374,430.2	4,261,745.9	112,684.3	97.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,459,422.3	2,453,367.9	6,054.4	99.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,584,979.4	1,618,397.4	(33,418.0)	102.1
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,749.0	22,176.4	30,572.6	42.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	277,279.5	167,804.2	109,475.3	60.5

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	67,506.6	(67,506.6)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	413,734.9	(413,734.9)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	9	9	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	191.5	191.5	0.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	309,851.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	292,781.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	244,481.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	71,298.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,218.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,400.0
2104	Хангамж, бараа материалын зардал	8,171.3
2105	Нормативт зардал	109,445.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,648.0
2107	Томилолт, зочны зардал	25.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,185.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,089.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,300.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,300.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,069.7
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	377,413.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	377,413.6
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	29,166.3
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	346,631.3
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,616.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	67,562.1

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын ТЕЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд дотоод хяналт, ер төлбөрийн данс, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариат сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 04-ны өдрийн 01/60 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тариат сум нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд зааснаар хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байна.

Тус сум нь тайлант онд “Сум орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө сэтгэл зүрхээ зориулан ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай чирэгдэлгүй хүргэх шадар туслагч нь байхад оршино” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Сумын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус сумын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариат сумын ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 4,374.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 43.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 32.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,992.7 сая төгрөгөөр буюу 41.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө	124.7	543.0	418.3	335.4
Авлага	472.9	376.7	(96.2)	(20.3)
Бараа материал	315.2	429.4	114.2	36.2
Үндсэн хөрөнгө	6,238.3	8,794.7	2,556.4	41.0
Нийт хөрөнгө	7,151.1	10,143.8	2,992.7	41.8
Өр төлбөр	285.0	17.1	(267.9)	(94.0)
Цэвэр хөрөнгө өмч /Засгийн газрын оролцоо, эздийн өмч/	6,866.1	10,126.7	3,260.6	47.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,151.1	10,143.8	2,992.7	41.8

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- *Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 335.4 хувиар өссөн байна.*

Мөнгөн хөрөнгийн 543.0 сая төгрөгийн үлдэгдлийн 475.4 сая төгрөг нь төрийн сангийн харилцах, 67.6 сая төгрөг нь төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 44.8 хувийг ОНХСангийн, 31.4 хувийг сум хөгжүүлэх сангийн, 12.6 хувийг ЭМТ-ийн, 11.4 хувийг орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл тус тус эзэлж байна.

- *Авлагын үлдэгдэл өмнөх оноос 20.3 хувиар буурсан байна.*

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан нь тайлант онд СХС-ийн зээл олгоогүйтэй холбоотой байна. Харин ЭМТ нь ковид цар тахалтай холбоотойгоор ЭМДС-аас 67.2 сая төгрөгийн авлагыг тайлагнажээ.

Нийт авлагын үлдэгдлийн 82.1 хувийг сум хөгжүүлэх сангийн, 17.9 хувийг ЭМТ-ийн авлага эзэлж байна.

- *Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 36.2 хувиар өссөн байна.*

Бараа материалын данс нь 315.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 492.8 сая, хандиваар 370.4 сая, шилжүүлэн авсан 52.5 сая, бусад 3.6 сая нийт 919.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 800.0 сая, шилжүүлсэн 1.8 сая, бусад 3.3 сая төгрөг нийт 805.1 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 429.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт бараа материал үлдэгдлийн 37.9 хувийг ЕБС-ийн, 24.5 хувийг ЭМТ-ийн, 18.2 ЗДТГ-ын, 7.8 хувийг бага сургуулийн, 7.7 хувийг хүүхдийн цэцэрлэгийн, 3.3 хувийг соёлын төвийн, 0.6 хувийг сумын ИТХ-ын бараа материалын үлдэгдэл тус тус эзэлж байна.

- *Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 41.0 хувиар өссөн байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 6,238.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 75.1 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 211.8 сая, шилжүүлэн авсан 2,952.1 сая, бусад 808.6 сая төгрөг нийт 4,047.6 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгө акталсан 189.2 сая, шилжүүлсэн болон бусад 870.9 сая, тайлант хугацаанд байгуулсан 431.1 сая төгрөгийн элэгдэл нийт 1,491.2 сая төгрөгөөр буурч, 8,794.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 35.2 хувийг ЗДТГ-ын, 21.4 хувийг ЕБС-ийн, 22.0 хувийг ЭМТ-ийн, 8.1 хувийг соёлын төвийн, 6.7 хувийг хүүхдийн цэцэрлэгийн 6.5 хувийг бага сургуулийн, 0.1 хувийг сумын ИТХ-ын үндсэн хөрөнгийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

- *Өр төлбөрийн үлдэгдэл нь өмнөх 94.0 хувиар буурсан байна.*

Өр төлбөрийн үлдэгдлийн 5.1 сая төгрөг нь бараа үйлчилгээний зардлын, 9.9 сая төгрөг нь байгууллагад төлөх, 2.0 сая төгрөг нь хувь хүмүүст төлөх өглөг тус тус байна

Нийт өр төлбөрийн 88.3 хувийг соёлын төвийн, 11.7 хувийг бага сургуулийн өр төлбөр эзэлж байна.

Соёлын төвийн өр нь сумын төвийн шинэчлэлийн ажлын хүрээнд нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотой Адуучин удам ХХК-д төлөх халаалтын төлбөр байна.

- *Цэвэр хөрөнгө өмч нь өмнөх оноос 47.5 хувиар өссөн байна.*

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 3,260.6 сая төгрөгөөр өссөн нь ЭМТ орон нутагт шилжиж, санхүүгийн тайланг суманд нэгтгүүлсэнтэй холбоотой 1,981.3 сая төгрөгөөр, тайлант үеийн үр дүн 1,279.3 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Татварын орлого	185.5	281.1	95.6
Татварын бус орлого	414.5	1,415.1	1,000.6
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,871.2	2,459.4	588.2
Орон нутгийн төсвөөс	1,449.5	1,331.1	(118.4)
Нэмэлт санхүүжилтийн орлого	26.3	444.6	418.3
НДСангаас санхүүжих	-	22.2	22.2
Үйл ажиллагааны орлогын дүн	3,947.0	5,953.5	2,006.5
Цалин, шимтгэлийн зардал	2,043.3	2,673.7	630.4
Бусад бараа үйлчилгээний зардал	661.6	1,242.7	581.1
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63.1	58.3	(4.8)
Бараа үйлчилгээний бусад зардал	427.2	513.6	86.4
Урсгал шилжүүлэг	663.8	103.0	(560.8)
Үйл ажиллагааны зардал	3,859.0	4,591.3	732.3
Үйл ажиллагааны бус зардал	140.2	82.9	(57.3)
Үйл ажиллагааны үр дүн	(52.2)	1,279.3	1,331.5

Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт өмнөх оноос 588.2 сая төгрөгөөр буюу 31.4 хувиар өсч, орон нутгийн төсвийн санхүүжилт 118.4 сая төгрөгөөр буюу 8.1 хувиар буурчээ. Татварын бус орлого 241.4 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буюу улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлуудыг орлогод авч, бүртгэж тайлагнасантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Орон нутгийн төсвийн орлого, зардлын төлөвлөлт

Орон нутгийн төсвийн орлогыг 231.3 сая төгрөгөөр анх төлөвлөж, дээд шатны байгууллагад хүргүүлснийг 130.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2020 оны 12 дугаар сарын 16-ны 07 дугаар тогтоолоор 361.9 сая төгрөгөөр баталсан байна.

Харин 2021 оны 9 дүгээр сарын 08-ны 19 дүгээр тогтоолоор нийт орлогыг 108.0 сая төгрөгөөр бууруулан 253.9 сая төгрөгөөр тодотгон баталсан бөгөөд энэ нь тайлант хугацаанд хэрэгжиж эхэлсэн малын тоо толгойн албан татварыг өндөр төлөвлөснийг бууруулсантай холбоотой байна.

Тариат сумын ИТХ-ын 2021 оны төсөв батлах тогтоолоор сумын нийт орлого, санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллагуудад олгох санхүүжилтийг 4,016.2 сая төгрөгөөр анх баталсан бол тодотгосон тогтоолоор 4,374.4 сая төгрөг болж, 358.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Төсвийн тодотголоор сургуулийн халаалтын 2019, 2020 оны өрийг барагдуулахад аймгаас дэмжлэг үзүүлж, шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 3. Сумын төсвийн төлөвлөлт

сая төгрөгөөр

№	Байгууллага, орлогын нэр төрөл	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Сумын төсвийн орлого	361.9	253.9	(108.0)
2	ТЕЗ-ийн харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого	152.6	152.6	-
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	772.2	1,122.5	350.2
4	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	103.9	109.6	5.8
5	СӨБ-ийн үйлчилгээ	409.5	360.3	(49.2)
6	ЕБС-ийн үйлчилгээ	1,328.9	1,428.8	100.0
7	Соёлын үйлчилгээ	99.0	99.0	-
8	ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээ	723.0	723.0	-
9	2020 оны ОН-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	15.0	57.2	42.2
10	2020 оны ОНХС-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	50.3	61.2	11.0
11	2020 оны СХС-ийн үлдэгдлээс санхүүжих	-	6.3	6.3
	Нийт дүн	4,016.2	4,374.4	358.2
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	67.1	67.1	0.0
2	Засаг даргын тамгын газар	406.0	473.2	67.2
3	Орон нутгийн хөгжлийн сан	386.7	295.5	(91.2)
4	Сум хөгжүүлэх сан	152.1	158.4	6.3
5	Сургуулийн өмнөх боловсрол	463.4	412.0	(51.4)
6	Ерөнхий боловсролын сургууль	1,679.4	2,106.8	427.4
7	Соёлын төв	99.0	99.0	-
8	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	762.5	762.5	-
	Нийт дүн	4,016.2	4,374.4	358.2

3.6.2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Тариат сумын ИТХ-ын 2021 оны төсөв тодотгон батлах тухай 2021 оны 12 дугаар сарын 17-ны 07 дугаар тогтоолд сумын төсвийн орлогоор 17 нэр төрлийн 254.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 293.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 115.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Сумын төсвийн орлого

сая төгрөгөөр

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1.НИЙТ ОРЛОГО	254.4	293.0	38.6	115.2
2.УРСГАЛ ОРЛОГО	254.4	293.0	38.6	115.2
3.ТАТВАРЫН ОРЛОГО	243.0	281.1	38.1	115.7
4.Орлогын албан татвар	62.4	89.7	27.2	143.6
Хүн амын орлогын албан татвар	62.4	89.7	27.2	143.6
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	-	-	-	-
Үйл ажиллагааны орлого	3.5	30.8	27.4	893.3
Хөрөнгийн орлого	34.8	52.2	17.3	149.8

Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	0.2	6.7	6.5	4,442.7
Шууд бус орлого	24.0	-	(24.0)	-
Өмчийн татвар	131.6	118.5	(13.1)	90.0
Малд ногдуулах албан татвар	124.6	112.0	(12.6)	89.9
Бууны албан татвар	6.9	6.4	(0.5)	92.6
Бусад татвар	49.0	73.0	24.0	148.9
Улсын тэмдэгтийн хураамж	5.1	4.8	(0.4)	92.8
Газрын төлбөр:	1.0	21.0	20.0	2,062.1
-----Газрын төлбөр	1.0	4.8	3.8	468.7
-----Газрын дуудлага худалдааны орлого	-	16.3	16.3	
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	5.0	3.1	(1.9)	61.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	9.3	14.3	5.0	153.6
Байгалийн нөөц ашигласны төлбөр:	28.6	29.8	1.3	104.5
.....Байгалийн ургамал ашигласны төлбөр	0.2	0.2	0.0	100.9
----- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.6	1.6	-	100.0
-----Ойн нөөц ашигласны төлбөр	26.5	27.8	1.3	104.8
-----Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	0.2	0.2	-	100.0
5.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11.4	11.9	0.5	104.0
Төсөвт газрын өөрийн орлого	0.5	0.7	0.2	148.0
Хүү торгуулийн орлого	10.0	10.2	0.2	102.1
Нэр заагдаагүй бусад орлого	0.9	0.9	0.0	100.6

Тайлант жилд 13 нэр төрлийн орлого давж биелсэн бол малын тоо толгойн албан татвар 12.6 сая төгрөгөөр, бууны албан татвар 0.5 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 0.4 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.9 сая төгрөгөөр тус тус тасарчээ. Энэ нь ЗГ-аас малын тоо толгойн албан татварыг 2021 оын 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулж, татвар хураалт оройтсон, сумын иргэний бүртгэлийн үйлчилгээ цахимжиж, уг үйлчилгээнээс төвлөрдөг тэмдэгтийн хураамж аймгийн орлогод төвлөрүүлдэг болсон, сумын хүрмэн чулууны олборлолт ашиглалтын үйл ажиллагааг зогсоосон зэрэгтэй холбоотой байна.

Харин шууд бус орлого 24.0 сая төгрөгөөр тасарсан нь ХХОАТ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2-т заасны дагуу үйл ажиллагааны орлогод малчин иргэдийн малын гаралтай түүхий эд борлуусан орлого хамаарч, ноос ноолуурын урамшууллаас авах татвар нь үйл ажиллагааны орлого руу тайлагнах болсноос шалтгаалжээ.

3.6.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 4,374.4 сая төгрөгийн төлөвлөснөөс 3,922.7 сая төгрөгийг урсгал зардалд, 295.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 156.3 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар төлөвлөж, нийт зардлын 2,459.4 сая төгрөг буюу 56.2 хувийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,585.0 сая төгрөг буюу 36.2 хувийг орон нутгийн төсвөөс, 277.3 сая төгрөг буюу 6.4 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, 52.7 сая төгрөг буюу 1.2 сая төгрөгийг НДС-аас санхүүжүүлэхээр хуваарилжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,915.5 сая төгрөг буюу 89.5 хувьтай байгаа нь урсгал зардлаас 49.3 сая төгрөг, хөрөнгийн зардлаас 253.3 сая төгрөг, сум хөгжүүлэх сангаас 156.3 сая төгрөгийг тус тус зарцуулаагүй, үлдэгдлээр байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 346.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.6 төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс авсан хандив тусламж 29.2 сая төгрөг 377.4 нийт төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлсний зардалд 71.3 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-д 5.2 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 3.4 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 8.2 сая төгрөг, нормативт зардалд 109.4 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 2.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 35.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 9.1 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 48.3 сая төгрөг, хөрөнгийн зардалд 17.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын засаг даргын нөөц санг 39.5 сая төгрөгөөр тодотгон баталж, бүрэн зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 67.7 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд ковид цар тахал, малын шүлхий өвчин болон өвөлжилтийн бэлтгэлд, 8.7 хувийг 2.1.4 дэх заалтын хүрээнд иргэд байгууллагаас тавьсан хүсэлтийг шийдвэрэлэхэд, 21.7 хувийг 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд, 1.9 хувийг 2.1.6 дахь заалтын хүрээнд шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт тус тус зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 107 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 83.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 4,374.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 3,915.5 сая төгрөгийг зарцуулж, 89.5 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 17 нэр төрлийн орлогоор 254.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 293.0 сая төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 115.2 хувь буюу 38.6 сая төгрөгөөр давж биелсэн боловч 4 нэр төрлийн орлого 15.4 сая төгрөгөөр төлөвлөснөөс тасарсан байна.

Сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Тариат сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 7 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Тариат сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 5. ТШЗ-ийн аудитын дүнгийн талаар

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЕБСургууль	1	1	1		1	1			
Хүүхдийн цэцэрлэг	1	1		1					
Бага сургууль	1	1		1					
ЗДТГ	1	1	1		1		1		
ИТХурал	1	1	1		1	1			
Соёлын төв	1	1	1		1	1			
ЭМТ	1	1	1		1		1		
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					
НИЙТ ДҮН	9	9	5	4	5	3	2	0	0

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитад хамрагдсан сумын ИТХ, ЕБС, Соёлын төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, харин ЗДТГ, ЭМТ-д “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг өгсөн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 88.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 10.8 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 56.2 сая төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 21.0 сая төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл сая төгрөг

Байгууллагын нэр	Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
					Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЕБСургууль			4	5.9			2	-	2	5.9
Хүүхдийн цэцэрлэг	1	5.9	-	-						
ЗДТГ	1	4.9	5	39.0			4	39.0	1	-
ИТХурал			2	1.1			1	1.1	1	-
Соёлын төв			4	19.6			2	4.5	2	15.1
ЭМТ			1	11.6			1	11.6		
НИЙТ ДҮН	2	10.8	16	77.2	-	-	10	56.2	6	21.0

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 44.6 сая төгрөгийн 5 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 32.6 сая төгрөгийн 11 зөрчил тус тус байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Эрүүл мэндийн төв нь 2021 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор нийт 11.6 сая төгрөгийн эм, боох материал санхүүгийн тайланд тусгаагүй зөрчил илэрсэнд аудитаас зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хүргүүлсэн байна.
- Соёлын төв нь 15.1 сая төгрөгийн нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотой өр төлбөртэй ажилласанд өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна.
- ЕБС нь цахим төлбөрийн баримтын 5.9 сая төгрөгийн баримтыг цахим төлбөрийн баримтын ebarimt.mn систем дутуу бүртгэсэн, дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хийгдээгүй зэрэг зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн байна.
- ЗДТГ нь Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулалттай холбоотой 11 захирамжийн хууль эрх зүйн үндэслэлийг оновчтой, тодорхой тусгаагүй, журмын хамааралгүй заалтыг оруулсан зэрэг зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тариат сумын ТЕЗ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 153 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуулинд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших зөвлөмжийг хүргүүллээ.

Тариат сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд ЗДТГ- 4, ИТХ- 3, соёлын төв -1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсанд зөвлөмж хүргүүлсэн.
- ЕБС- тайлант онд шилэн дансанд 149 мэдээлэл байршуулахаас, 11 мэдээлэл огт оруулаагүй, 17 мэдээлэл хугацаа хоцроосон зөрчил илэрч албан шаардлага хүргүүлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Тариат сумын ТЭЗ-ийн харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Төсвийн хэмнэлтийг 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд ЗДТГ 4.2 % буюу 7.0 сая төгрөг, Соёлын төв 8.1 хувь буюу 2.1 сая төгрөг, ИТХ 10 хувь буюу 1.1 сая төгрөгийн нийт 10.2 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.
- Соёлын төв нь 2.4 сая төгрөгийн дрон, ЗДТГ нь 20.0 сая төгрөгөөр хог ачих зориулалт бүхий автомашин тус тус худалдан авсан байна. Энэ нь Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4-т “Энэ тогтоол батлагдахаас өмнө төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, ... тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.
- ЗДТГ нь тайлант онд 2 орон тоогоор илүү ажилласантай холбоотойгоор 11.9 сая төгрөгийн цалин хөлсийг олгосон зөрчил илэрсэн. Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар 1.2-т “Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд дээрх зөрчлүүдэд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах **албан шаардлагуудыг** хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 98.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт сая төгрөг

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж-СХС	1	86.2			1	86.1	0
Зөвлөмж- Орлого	1	11.9	1	10.5		1.4	88.2
Зөвлөмж- Өр төлбөр	1	0	1	0			95.0
Нийт	3	98.1	2	10.5	1	87.5	61.1

Өмнөх зөвлөмжийн дагуу СХС-ийн авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаж байгаа талаар албан бичгээр хариуг ирүүлсэн боловч тайлант онд ковид цар тахалтай холбоотойгоор хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оноос өссөн байна. Өмнөх онд 4 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг тасарсанд зөвлөмж хүргүүлснээр 3 нэр төрлийн орлогын биелэлтийг хангууллаа.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, СХС-ийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн буцаан төвлөрүүлэлт болон Хоршоо хөгжүүлэх сангийн журмын хэрэгжилтийг авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 110.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, зөрчлийг арилгуулах, таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлж, өр төлбөр болон дотоод хяналттай холбоотой зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Албан шаардлага

- Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг тулган шалгахад малын тоо толгойн албан татвар 12.6 сая төгрөгөөр, бууны албан татвар 0.5 сая төгрөг, улсын тэмдэгийн хураамжийн орлого 0.4 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.9 сая төгрөг нийт 15.4 сая төгрөгөөр орон нутгийн орлого тасарсан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж, орлогын төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн хийж, нэр төрлөөр жигд ханган биелүүлэх албан шаардлагыг хүргүүллээ.

- Сум хөгжүүлэх сангаас зээлийн авлагыг тулган шалгахад 3 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн 16.2 сая, 11 зээлдэгчтэй холбоотой чанаргүй 79.0 сая, нийт 14 зээлдэгчтэй холбоотой 95.2 сая төгрөгийн төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмын /тухайн үед хүчин төгөлдөр байсан/ 4.7-д “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу төвлөрүүлэхэд онцгой анхаарч, зээлийг барагдуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тариат сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн бөгөөд “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын соёлын төвийн 15.1 сая төгрөгийн өр төлбөр нь тус суманд хэрэгжсэн сумын төвийн шинэчлэлийн ажлын хүрээнд нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотой “Адуучин удам”ХХК-д өгөх халаалтын өрийн үлдэгдэл байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”гэсэн заалтыг зөрчсөн мөн санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын удирдлагын зүгээс өр төлбөрийг барагдуулах талаар шат дараатай тодорхой арга хэмжээг авч ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Тариат сумын ТЕЗ	4	110.6	0	0	0	0	2	110.6	2	0
	Дүн	4	110.6	0	0	0	0	2	110.6	2	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Тариат сумын ТЕЗ	1	0	0	0	0	0	0	0	1	0
	Дүн	1	0	0	0	0	0	0	0	1	0
	Нийт дүн	5	110.6	0	0	0	0	2	110.6	3	0